



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.6 дахь заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 91,007,231.00 (ерэн нэгэн сая долоон мянга хоёр зуун гучин нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал С.Баатаржав, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны дарга Х.Доржсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



0000143

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
80 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (мян.км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас элох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
1	Авеко, 02-85 УБҮ (арал-lnva1ca247v08648)	2008	261092	20,685,531.00	20,685,531.00	-	300,000.00
2	Хьюндай аксент, 30-11 УБС (арал-kmhva21lptu201251)	2006	472175	4,000,000.00	4,000,000.00	-	250,000.00
3	Хьюндай аксент, 07-53 УБД (арал-kmhua21nptu145123)	2005	256706	3,450,000.00	3,450,000.00	-	250,000.00
4	Хьюндай аксент, 02-29 УБҮ (арал-kmhcm41ap8u222777)	2008	384797	15,801,900.00	15,801,900.00	-	300,000.00
5	Хьюндай аксент, 02-21 УБҮ (арал-kmhcm41ap8u230069)	2008	377465	15,231,800.00	15,231,800.00	-	300,000.00
6	Хьюндай аксент, 02-27 УБҮ (арал-kmhcm41aabu547739)	2010	292432	19,500,000.00	19,500,000.00	-	300,000.00
7	Хьюндай старекс, 21-01 УБС (арал-kmijwwh7bruo53848)	2006	449807	5,000,000.00	5,000,000.00	-	350,000.00
8	Мицубуши делика, 53-33 УБН (арал-re8w-0118612)	2005	421135	7,338,000.00	7,338,000.00	-	400,000.00
	Нийт дүн			91,007,231.00 (ерэн нэгэн сая долоон мянга хоёр зуун гучин нэг)			2,450,000.00 (хоёр сая дөрвөн зуун тавин мянган)